

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ИХ СУНГАА МОНГОЛ ХЭЛ Хувилбар А

Тэмээний хүн

Эхтэйгээ нийлэхээр цахилж яваа саахалтын хурганы хойноос цогьж явснаа гэнэт жолоо татан эргэж тэмээ рүүгээ давхлаа. Эргэж ч харсангүй. Мэдээж нийллээ. Хурга буцаасангүй гэж над дээр тохоогдохоор үл барам хойноос нь явж байснаа эргэчихнэ билээ ч гэж ярьж байгаа. Зарим нь бүр "Өөрийнхөө хургыг бол буцаасан даа. Санаа муутай солиг. Яав ч олигтой амьтан болохгүй гэж шуугьж байгаа." гэж бодохоос гомдон гол харлана.

Гэтэл гэгээтэй дээр тэмээгээ цуглуулаад харьчихвал маргааш айл саахалтаараа нүүж, нуур ногоо халгисан шинэ нутагт бууцгаах юм чинь энэ нэг оройн сааль юу ч биш гэж заяа нь бодохгүй дээ гэж бодохоос уур ч хүрэх шиг санагдана.

Гэвч анх удаа, аяны хүн айлын нохойтой зодолдож, аргалын хүнтэй сатаардаггүй юм гэж захидгийг нь биелүүлсэн дээ гэсэн ганц бодол намайг өмөөрнө. (Д.Батбаяр)

1. Эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.

- A. Ус үзэлгүй гутал тайлж, уул үзээгүй хормой шуух.
- B. Жингийн цуваа явж л байдаг, замын ноход хуцаж л байдаг.
- C. Галуу дуурайж, хэрээ хөлөө хөлдөөх.
- D. "А" гэсэн үсэгт ацаг тавьж мэдэхгүй, арав гэсэн тоонд тэг тавьж чадахгүй.
- E. Чээжин дотор түймэр шатавч утааг нь хамраараа бүү гарга.

2. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.

- A. Аяны хүн айлын нохойтой зодолдож, аргалын хүнтэй сатаардаггүй юм.
- B. Шинэ нутагт бууцгаах юм чинь энэ нэг оройн сааль юу ч биш.
- C. Өөрийнхөө хургыг бол буцаасан даа. Санаа муутай солиг.
- D. Хойноос нь явж байснаа эргэчихнэ билээ.
- E. Яав ч олигтой амьтан болохгүй гэж шуугьж байгаа.

3. Зохиолч, би баатрын сэтгэл тогтворгүй байгааг ямар ямар үгээр илэрхийлсэн бэ?

- A. буцаасангүй, харсангүй, ярих
- B. цогих, давхих, давхлаа
- C. бодох, биелүүлэх, өмөөрөх
- D. зодолдож, сатаардаггүй, ярьж байгаа
- E. гомдох, гол харлах, уур ч хүрэх шиг

4. "Эхтэйгээ нийлэхээр цахилж яваа саахалтын хурга..." гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.

- A. Ёгтлол
- B. Ихэсгэл
- C. Амьдчилал
- D. Адилтгал
- E. Тойруулал

5. Эхийн хэсгүүдийг өгүүлбэрээр хураасныг зөв дараалалд оруулаарай.

- A. жолоо татан эргэв, зарим нь шуугьж байгаа, гомдож гол харлана, мэдээж нийллээ, уур ч хүрэх шиг санагдана, нохойтой зодолдож хүнтэй сатаардаггүй, бодол намайг өмөөрнө.
- B. жолоо татан эргэв, мэдээж нийллээ, гомдож гол харлана, зарим нь шуугьж байгаа, уур ч хүрэх шиг санагдана, бодол намайг өмөөрнө.
- C. жолоо татан эргэв, мэдээж нийллээ, нохойтой зодолдож хүнтэй сатаардаггүй, зарим нь шуугьж байгаа, гомдож гол харлана, уур ч хүрэх шиг санагдана, бодол намайг өмөөрнө.
- D. жолоо татан эргэв, бодол намайг өмөөрнө, мэдээж нийллээ, гомдож гол харлана, зарим нь шуугьж байгаа, уур ч хүрэх шиг санагдана.
- E. жолоо татан эргэв, мэдээж нийллээ, зарим нь шуугьж байгаа, гомдож гол харлана, уур ч хүрэх шиг санагдана, бодол намайг өмөөрнө.

6. "Өөрийнхөө хургыг бол буцаасан даа. Санаа муутай солиг. Яав ч олигтой амьтан болохгүй гэж шуугьж байгаа" гэсэн хэсгийн тодруулсан үгсийг ямар үгээр солин найруулбал оновчтой вэ?

- A. ялгасан даа, тархи, цуурч байлаа
- B. тойруулсан даа, монди, цуурч байлаа
- C. эргүүлсэн дээ, монди, шаагьж байгаа
- D. аргалсан даа, хог, загнаж байлаа
- E. ойртуулсан даа, монди, бодож байгаа

7. "Нуур ногоо халгисан шинэ нутагт бууцгаах юм чинь энэ нэг оройн сааль юу ч биш гэж заяа нь бодохгүй дээ" зохиомжийг зөв ялган тодорхойлоорой.

- A. Зохиолчийн тэмдэглэл
- B. Дотоод буюу ганцаар яриа
- C. Харилцан яриа
- D. Баатрын хөрөг
- E. Байгалийн зураглал

8. "Аяны хүн айлын нохойтой зодолдож, аргалын хүнтэй сатаардаггүй юм гэж захидгийг нь биелүүлсэн дээ гэсэн ганц бодол намайг өмөөрнө" өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?

- A. Харамссан өнгө аяс
- B. Хүсэн тэмүүлсэн өнгө аяс
- C. Баталж нотолсон өнгө аяс
- D. Сургамжилсан өнгө аяс
- E. Шүүмжилсэн өнгө аяс

9. Хүншүүлэх ур маягт тохирох өгүүлбэрийг олоорой.

- A. Нуур ногоо халгисан нутагт буух.
- B. Ганц бодол намайг өмөөрнө.
- C. Эргэж ч харсангүй. Мэдээж нийллээ.
- D. Яав ч олигтой амьтан болохгүй.
- E. Энэ нэг оройн сааль юу ч биш.

10. Дараах өгүүлбэрүүдийн утгын харьцааг тодорхойлоорой.

"Аяны хүн айлын нохойтой зодолдож, аргалын хүнтэй сатаардаггүй"

- A. Ойролцоо утгат
- B. Төсөөт утгат
- C. Эсрэг утгат
- D. Зүйлчилсэн утгат
- E. Төсөөт ба зүйлчилсэн утгат

11. "....." гэгчээр эцэст нь чи намайг буруутгах гэж. цэгийн оронд тохирох хэлцийг олоорой.

- A. Ганган хүн сэрүүнд, жороо морь хаварт
- B. Олноор зөвлөвөл осол бага
- C. Садантай хүн, салаатай мод
- D. Нохой хамартаа хүрэхэд усч
- E. Ишиг эврээ ургахаар эхийгээ

12. "Аяны хүн айлын нохойтой зодолдож, аргалын хүнтэй сатаардаггүй юм гэж захидгийг биелүүлсэн дээ" өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.

- A. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
- B. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
- C. Угсарсан нийлмэл өгүүлбэр
- D. Холимог нийлмэл өгүүлбэр
- E. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр



13. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.
 А. Би хурга буцаав. В. Хүмүүс шаагьж байлаа. С. Би хурганы хойноос цогив.
 D. Би тэмээгээ хураав. E. Айлын ноходтой зодолдож болохгүй.
14. “Эхтэйгээ нийлэхээр **цахилж яваа** саахалтын хурганы хойноос цогьж явснаа гэнэт жолоо татан эргэж тэмээ рүүгээ давхилаа” онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
 А. харьяаны тодотгол В. өгүүлэгдэхүүн С. өгүүлэхүүн
 D. тодотгол E. хамжсан тодотгол
15. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
 А. Говь-Алтай аймгийн Цээл сумын нийт нутгийн 40% нь үлийн цагаан оготнод баригджээ.
 В. Хойд талын хоёр шавар байшингийн баруун талынх нь тэр чавганцынх гэж байгаа.
 С. Уншигчийн анхаарал, сонирхлыг татахад эсээний эхлэл нь нэн чухал үүрэгтэй юм.
 D. Бүрэн дунд боловсролын Цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.
 E. Өвгөн жолооч ухасхийн, хийг нэмэхүй дор дөрвөн хүрд чөлөө завгүй эргэлдэнэ.
16. Төрөл биш утгатай үгийг олоорой.
 А. явц В. явдал С. явуул D. явуут E. явуу
17. “Аяны хүн айлын нохойтой зодолдож, **аргалын** хүнтэй сатаардаггүй” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
 А. Сүвэгчилсэн ухаан, юмыг хийх бүтээхэд олсон барил
 В. Ачих тээх зүйлийг агуулах, бургасыг матаж, үдээрээр боож хийсэн сав
 С. Амьтан, хонин гөрөөсний эм
 D. Үхэр малын хатсан баас
 E. Нарны эргэлт явдлыг баримталж, цаг улирлыг тоолох зурхай ёсон
18. “Тэр гуйлгачны эрдэм ч нохой долоож үх дээ” гэж Бадарч хэлээд мориноосоо буув. өгүүлбэр найруулгын ямар зэрэгт хамаарах вэ?
 А. Хүндэтгэлийн В. Дунд С. Дээд D. Нутгийн аялгуу E. Доод
19. “Өөрийнхөө хургыг бол буцаасан даа. Санаа муутай золиг. Яав ч олигтой амьтан болохгүй” өгүүлбэрээс зэрэгцүүлэн онцлох утгатай бүтээврийг олоорой.
 А. сан В. даа С. ч D. бол E. гүй
20. Зөв бичсэн бүлэг үгсийг олоорой
 А. аргачлал, тугаллалаа, хүргье, ганзага, ховлох
 В. гүйцэтгэе, дараах, домчийн, сурагчдадаа, мөстөх
 С. буталлаа, идэвхи, сэвстэх, гийгүүлэгчийн, номч
 D. нөхөддөө, төлөвлөлөө, уяя, бодхоос, сонстох
 E. төрлөхтний, хомстох, байгууллаа, жуулчилалаа
21. “.....цуваа цэгийг (...) тавина” дүрмийг гүйцээж бичээрэй.
 А. Номын нэр, бүлэг, гарчиг, албан газрын хаягийн ард
 В. Хүүрнэсэн өгүүлбэрийн эцэст
 С. Өгүүлбэр төгсөөгүй буюу өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд
 D. Аливаа хүний хэлсэн үг, бодол санаа зэргийг бичихдээ
 E. Ерийн байдлаар захирсан өгүүлбэрийн эцэст
22. “нэрлэсэн” хэмээх үгэнд холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой.
 А. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ.
 В. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ.
 С. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ.
 D. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ.
 E. Хэрэв –л дагаврыг залгахад өмнөх балархай эгшиг гээгдэхээр байвал эгшгийг ард нь бичнэ.
23. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.
 1. жүжиг а) Ш.Сүрэнжав “Би тэнгэрийн хүү”
 2. роман б) А.Рыбаков “Арбатын хүүхдүүд”
 3. тууж в) Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр”
 4. яруу найраг г) Л.Өлзийтөгс “Аквариум”
 5. өгүүллэг д) Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс”
- А.1b,2d,3e,4a,5c В.1c,2b,3d,4a,5e С.1c,2d,3a,4b,5e
 D.1c,2b,3e,4a,5d E.1b,2c,3e,4a,5d
24. Дараах эшлэлүүдээс нар, сарны дүрслэл нь бусдаасаа ялгаатай хэсгийг олоорой.
 А. Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог
 Тэнгэрийн хэвтэр буурал тал минь
 В. Саваа дүүрэн мэлтэлзэх Онон, Хэрлэнгийн урсгал
 Сартай шөнөөр ажихад мөнгөн хээтэй байв
 С. Ботго нь гунганах сүргийн дэргэдээс
 Гэгээ татан наран ургана
 D. Шөнийн чимээгүй гадаа налайн
 Унийн углуургаар саран гэрэлтэнэ
 E. Харах нүдэнд гийсэн саран чи минь хө
 Халгих зүрхэнд шингээсэн гэгээтэй
25. “Авах гээхийн дөрвөн мөрт” шүлэгт дарааллаар тохирох хэсгийг олоорой.
Дөрвөн буй аль буй хэмээвээс
 Хэн дор эрдэм буй болвоос түүн дор.....буй
 Хэн дор эе буй болвоос түүн дор.....буй
 Хэн дор эд буй бөгөөс түүн дор.....буй
 Хэн дор эрх буй бөгөөс түүн дор.....буй
- А. тус, нөхөр, харам, хилэнц
 В. нөхөр, тус, хилэнц, харам
 С. нөхөр, тус, харам, хилэнц
 D. тус, нөхөр, хилэнц, харам
 E. харам, хилэнц тус, нөхөр,

26. Зөв бичсэн хэсгийг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2} = x^{-2}$
 B. $\frac{1}{x^2} = x^{-2}$
 C. $\frac{1}{x^2} = x^{-2}$
 D. $\frac{1}{x^2} = x^{-2}$
 E. $\frac{1}{x^2} = x^{-2}$

27. “үндэс” гэсэн үгийг Монгол бичгээр зөв бичсэнийг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

28. Нэрийн тийн ялгалын нөхцөлийг буруу дагуулсан үгийг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

29. “ $\frac{1}{x^2}$ ” үгст олон тооны дагаврын алийг залгах вэ?

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

30. “хөтөл” гэсэн үгийг үйлийн хэвийн дагавраар зөв хувилгасныг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

31. Цэгийн оронд тохирох нөхцөлийг олж зүйр цэцэн үг бүтээгээрэй.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

32. Монгол бичгийн эхийг уншаад зөв хөрвүүлснийг олоорой.

$\frac{1}{x^2} = x^{-2}$
 $\frac{1}{x^2} = x^{-2}$
 $\frac{1}{x^2} = x^{-2}$
 $\frac{1}{x^2} = x^{-2}$

- A. Эцгийн сургаалаар явагч
 Эрдэм билэг сурахад дуртай
 B. Эхний сургуулиар явагч
 Эрдэм билэг сурахад дуртай
 C. Эхний сургаалаар явагч
 Эрдэм бичиг сурахад дуртай
 D. Эцгийн сургаалаар яваач
 Эрдэм бичиг сурахад дуртай
 E. Эцгийн сургаал эрдэм
 Эхийн сургаал эрдэнэ.

33. “унаа хөсөг” гэсэн утгыг илэрхийлэх үг аль нь вэ?

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

34. Буруу бичсэн үгийг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

35. Дараах өгөгдлөөс “гараг эрхэс” гэсэн утгыг илтгэх үгийг олоорой.

- A. B. C. D. E.

A. $\frac{1}{x^2}$
 B. $\frac{1}{x^2}$
 C. $\frac{1}{x^2}$
 D. $\frac{1}{x^2}$
 E. $\frac{1}{x^2}$

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

a. Аавдаа адуу манахыг заах	1. Зүүд нийцэхгүй дэмий чалчих буюу боломжгүй дэмий үйл үйлдэх
b. Дайснаа ирэхэд дариа нухах	2. Этгээд гажууд, сонин хачин ааш авиртай
c. Ямаанаас янзтай, тэмээнээс гэдгэр	3. Өөрөөсөө ахмад эсвэл мэдлэгтэй хүнд дэмий, илүү үг хэлэх
d. Илжгэнд эвэр ургуулах	4. Туйлын харгис хэрцгий этгээд
e. Чонын зүрх, нохойн элэгтэн	5. Аливаа бэлтгэл зориулагдсан үйл явдлынхаа өмнө дууссан байх ёстой

2.2 Уран зохиолын төрөл зүйлүүдийг зохиолын хэсэгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------|---|
| a. Ерөөл | 1. Оройн очир шилждэг
Огторгуйн нар шингэдэг |
| b. Магтаал | 2. Манай нутагт Гомбо гэж нэг залуу хархүү байсан юм. Эцгээсээ өв хөрөнгө нэлээд хэдэн малтай үлдсэн. |
| c. Зүйр цэцэн үг | 3. Долоон бурхан одны дунд байдаг арай бүдгэвтэр од нь хааны гүнж юмсанжээ. |
| d. Өгүүллэг | 4. Өнөөдрийн өдрийг үүрдийн сайн гэж
Өндөр дэнж дээр өргөөгөө барьж байгаа юм байна |
| e. Домог | 5. Арын харгай мод нь
Альхан талаасаа яралзанхан харагдаад |

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

	1	2	3	4	5
a. Балархай эгшиг гээгдэх үг	аймаг+аас	Завхан+ы	сонссон+оо	эхлэх+ээр	дүрс+ийг
b. Зөөлний тэмдэг үл солигдох үг	барь+мт	цохь+сон	ахь+ж	хумь+на	холь+дог
c. "-я"-г шууд залгах үг	хүргэ	үгт	хая	урамшуул	өдөө
d. Эр үгэнд "-ыг" бичих үг	араг	бахь	харамч	айл	нухаш
e. "-л" ардаа эгшигтэй бичигдэх үг	борц+л	тос+л	онц+л	ноорог+л	ноос+л

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

a. 	1. босож суух
b. 	2. болно шүү!
c. 	3. суу билиг
d. 	4. сугандаа хавчуулах
e. 	5. сох дутах

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ИХ СУНГАА МОНГОЛ ХЭЛ Хувилбар D

Би аргалчин

Наймтайдаа би адуунд өшиглүүлж бэртээд сургуульд явж чадаагүй юм. Тэгээд “мэдрэл муудсан” гэж нутгийн нэг “доохторын” айлдсанаар арав хүртлээ хөдөө байж аргалчин болсон билээ. Бургасан шээзгий үүрч, хулсан савар бариад, хонины бэлчээрт хүрээгүй хүн аргал түүхийн жаргалыг яахан мэднэ.

Аргалчин хүн яруу найрагч мэт үргэлж эрэлд хатаж, түүнийгээ ямагт олж байдаг юм. Муу аргалчин малын чийртэй гэрийн хаяанаас үл холдон үнгэгдсэн хомоол, хөлдүү хоргол сэлтээр араг шээзгийгээ дүүргэвч тэр нь гал болохоосоо утаа болж, нүдийг нь хорсгох бүлгээ. Харин сайн аргалчин гэрийн бараа тасартал сэргэг бэлчээрт хүрч өвөлжин урьшиж, хаваржин хатсан намрын халтар аргалаар араг дөрвөлжөө дүүргээд, буцахдаа тааралдах олзыг ч гээлгүй хормойлно.

Тэгээд аргалын гал тулган дотор цогтойхон найраг шиг дүрэлзэх агшинд хол явсны ид сая нэг гарч, араг оосорлосон оёмол дээсний мөрөнд шигдсэн хөндүүр өөрөө арилдаг билээ. Аргал түүхдээ би дуртай, халтар аргал олдоосой гэж дуулна. Тэртээ цэнхэр уулсыг давахсан гэж дуулна. Сургуульд явчихсан үеийн нөхдөө дурсан дуулна. Энэ бүхнийгээ ганц мэдэх “Эрэлхэг Монголынхоо” аяар л дуулдаг байлаа.

Сургуулийг би төсөөлөн бодохдоо ном, дуу хоёр заалгачаад дараа нь олуулаа нийлээд, аргалдаа явдаг байх гэж санана.

Тэгээд миний өдөлж амжаагүй цурам ухаанд араг үүрсэн олон хүүхэд дүрслэгдээд, улмаар лавшруулан бодож, ганц сайхан том аргал тааралдвал овоорон булаацалддаг байхдаа хэмээн эзгүй хээр өөрийгөө цочтол тожигнон инээдэг сэн. (Ж.Лхагва)

1. Эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.

- A. Гүзээнд наалдсан дэлүү шиг.
- B. Харганын унгас түүж эсгий хийх.
- C. Чөтгөрийн бага нь адтай.
- D. Эрлийг сургаар олдог, эрдмийг хичээлээр сурдаг.
- E. Бяруу болоогүй байж бух болох.

2. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.

- A. Ном, дуу хоёр заалгачаад дараа нь олуулаа нийлээд, аргалдаа явдаг байх.
- B. Булаацалддаг байхдаа хэмээн эзгүй хээр өөрийгөө цочтол тожигнон инээдэг сэн.
- C. Савар бариад, хонины бэлчээрт хүрээгүй хүн аргал түүхийн жаргалыг яахан мэднэ.
- D. Сургуульд явчихсан үеийн нөхдөө дурсан дуулна.
- E. Аргалчин хүн яруу найрагч мэт үргэлж эрэлд хатаж, түүнийгээ ямагт олж байдаг юм.

3. Зохиолч, би баатрын хүсэл мөрөөдлийг ямар ямар үгээр илэрхийлсэн бэ?

- A. өшиглүүлж, яахан мэднэ, мэдрэл муудсан, тожигнотол инээдэг сэн
- B. цурам ухаан, олон хүүхэд, хонины бэлчээр, овоорон булаацалдах
- C. олон хүүхэд, бургасан шээзгий, хулсан савар, ном дуу хоёр
- D. халтар аргал олдоосой, уулсыг давахсан, дурсан дуулна, төсөөлнө
- E. гал тулга, цогтой найраг, дүрэлзэх агшин, сургууль, халтар аргал

4. “Аргалчин хүн яруу найрагч мэт үргэлж эрэлд хатаж, түүнийгээ ямагт олж байдаг юм” гэсэн өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тодорхойлоорой.

- A. Ёгтлол
- B. Ихэсгэл
- C. Адилтгал
- D. Амьдчилал
- E. Тойруулал

5. Эхийн хэсгүүдийг өгүүлбэрээр хураасныг зөв дараалалд оруулаарай.

- A. Муу аргалчин сайн аргалчин, мөрөөдөл хүслээ дуулна, мөрөөдлийн сургууль, аргалчин болов.
- B. Аргалчин болов, мөрөөдөл хүслээ дуулна, муу аргалчин сайн аргалчин, мөрөөдлийн сургууль.
- C. Аргалчин болов, муу аргалчин сайн аргалчин, мөрөөдөл хүслээ дуулна, мөрөөдлийн сургууль.
- D. Муу аргалчин сайн аргалчин, мөрөөдлийн сургууль, мөрөөдөл хүслээ дуулна, аргалчин болов.
- E. Аргалчин болов, мөрөөдөл хүслээ дуулна, мөрөөдлийн сургууль, муу аргалчин сайн аргалчин.

6. “Сайн аргалчин гэрийн бараа тасартал **сэргэг** бэлчээрт хүрч өвөлжин урьшиж, хаваржин **хатсан** намрын халтар аргалаар араг дөрвөлжөө дүүргээд, **буцахдаа** тааралдах олзыг ч гээлгүй хормойлно” гэсэн хэсгийн тодруулсан үгсийг ямар үгээр солин найруулбал оновчтой вэ?

- A. эзгүй, нойтон, наашлахдаа
- B. онгон, хорчийсон, очихдоо
- C. зэлүүд, үхэшсэн, хүрэхдээ
- D. соргог, эвэршсэн, эргэхдээ
- E. хээр, чийгтэй, зүглэхдээ

7. “Сургуулийг би төсөөлөн бодохдоо ном дуу хоёр заалгачаад дараа нь олуулаа нийлээд, аргалдаа явдаг байх гэж санана.” зохиомжийг зөв ялган тодорхойлоорой.

- A. Байгалийн зураглал
- B. Орчны дүрслэл
- C. Харилцан яриа
- D. Баатрын хөрөг
- E. Зохиолчийн тэмдэглэл

8. “Аргал түүхдээ би дуртай, халтар аргал олдоосой гэж дуулна” өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?

- A. Хүсэн тэмүүлсэн өнгө аяс
- B. Баталж нотолсон өнгө аяс
- C. Харамссан өнгө аяс
- D. Сургамжилсан өнгө аяс
- E. Шүүмжилсэн өнгө аяс

9. Адилтгах ур маягт тохирох өгүүлбэрийг олоорой.

- A. Халтар аргалаар араг дөрвөлжөө дүүргээд, буцахдаа тааралдах олзыг ч хормойлно.
- B. Араг оосорлосон оёмол дээсний мөрөнд шигдсэн хөндүүр өөрөө арилдаг билээ.
- C. “Мэдрэл муудсан” гэж нутгийн нэг “доохторын” айлдсанаар арав хүртлээ хөдөө байв.
- D. Аргалын гал тулганд цогтойхон найраг шиг дүрэлзэх агшинд хол явсны ид гарна.
- E. Олуулаа нийлээд, аргалдаа явдаг байх гэж санана.

10. Дараах өгүүлбэрүүдийн утгын харьцааг тодорхойлоорой.

“Муу аргалчин малын чийртэй гэрийн хаяанаас үл холдоно, Сайн аргалчин гэрийн бараа тасартал сэргэг бэлчээрт хүрнэ”

- A. Төсөөт утгат
- B. Эсрэг утгат
- C. Ойролцоо утгат
- D. Зүйлчилсэн утгат
- E. Төсөөт ба зүйлчилсэн утгат

11. “Хүүе Даваа, чи юугаа чалчаад суучхав” цэгийн оронд тохирох хэлцийг олоорой.
- A. Дүлий дүмбэ оргиод
B. Далан таваар бууж өгөөд
C. Долоон булчирхайгаа дэлгээд
D. Амаа үдүүлсэн юм шиг
E. Ус балгасан юм шиг
12. “Бургасан шээзгий үүрч, хулсан савар бариад, хонины бэлчээрт хүрээгүй хүн аргал түүхийн жаргалыг яахан мэднэ” өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
- A. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
B. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
C. Угсарсан нийлмэл өгүүлбэр
D. Холимог нийлмэл өгүүлбэр
E. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр
13. Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.
- A. Аргал түүхийн жаргалыг яахан мэднэ.
B. Хүүхдүүд аргалд явдаг.
C. Бургасан шээзгий үүрэв.
D. Олон хүүхэд дүрслэгдэв.
E. Аргалчин аргал түүв.
14. “Араг оосорлосон оёмол дээсний мөрөнд шигдсэн **хөндүүр** өөрөө арилдаг билээ” онцолсон үг өгүүлбэрт ямар гишүүн болох вэ?
- A. өгүүлэгдэхүүн
B. өгүүлэхүүн
C. харьяаны тодотгол
D. тодотгол
E. хамжсан тодотгол
15. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Намайг Төмөрсүх гэнэ, Янжингийн босоо ороолон ч гэнэ.
B. Царайных нь өнгө энэ нүгэлт ертөнцөд амьдрах өдөр тоотой хүн гэдгийг илтгэнэ.
C. Доржийг би сүүлийн гурван жил математикийн хичээл зааснаар мэднэ.
D. Хурдаа нэмэх жамаар хүн төрөлхтөн хөгжиж байна. Энэнээс өөр жам ёс үгүй.
E. Бат овогтой Дорж нь 1995 онд Сэлэнгэ аймгийн Номгон сумд төрсөн.
16. Төрөл биш утгатай үгийг олоорой.
- A. дуулга
B. дуулал
C. дуучин
D. дуурь
E. дуудлага
17. “Муу аргалчин малын **чийртэй** гэрийн хаяанаас үл холдоно” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой.
- A. Амьтны явсан мөр
B. Чихэнд чийр болох
C. Зориг хатуужилтай
D. Чадалтай чийрэг хүчирхэг
E. Чирэгдэх
18. Нутгийн нэг “доохторын” айлдсанаар арав хүртлээ хөдөө байж аргалчин болсон билээ. өгүүлбэр найруулгын ямар зэрэгт хамаарах вэ?
- A. Нутгийн аялгуу
B. Дунд
C. Доод
D. Дээд
E. Ерийн
19. “Тэртээ цэнхэр уулсыг давахсан гэж дуулна. Сургуульд явчихсан үеийн нөхдөө дурсан дуулна. Энэ бүхнийгээ ганц мэдэх “Эрэлхэг Монголынхоо” аяар л дуулдаг байлаа” өгүүлбэрээс салган онцлох утгатай бүтээврийг олоорой.
- A. гэж
B. л
C. ыг
D. на
E. хоо
20. Зөв бичсэн бүлэг үгсийг олоорой
- A. ширхэгээр, нутгийн, даавралсан, байдгийг, эрхт
B. захисан, цовхчихыг, хүртэлх, овгийн, ундарга
C. явдалаар, таягийг, даахьрсан, хуваарь, сүүдрээс
D. больсон, очхлоор, захидгыг, харцгийг, чүдэнз
E. учрыг, хэсгийг, дараагын, авьяастай, шатахуун

21. “.....анхаарлын тэмдэг (!) бичнэ” дүрмийг гүйцээж бичээрэй.
- A. Үйл явдлыг цуваа цагт хүүрнэсэн өгүүлбэрийн эхэнд
B. Ерийн байдлаар захирсан өгүүлбэрийн эцэст
C. Асуусан өгүүлбэрийн эцэст
D. Сэтгэл ихэд хөдлөн хэлсэн өгүүлбэрийн эцэст
E. Нэг санаа илэрхийлсэн олон өгүүлбэрийн эцэст

22. Хэн бэ? хэмээх өгүүлбэрт холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой.
- A. Эгшигт гийгүүлэгч үсэг үгэнд орохдоо заавал эгшигтэй бичигдэнэ.
B. Үгийн дунд л, м, н, в үсгийн дараа б үсгийг бичнэ.
C. Үгийн эхэнд э, ө, у байвал хойшид э дагана.
D. Эгшгийг гээх зэргээр балархай эгшгийн дүрмийг зөрчиж болохгүй
E. Хоёр үгнээс бүтсэн үгэнд заавал эгшиг жийрэглэнэ.

23. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|----------------|--|
| 1. жүжиг | a) Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана” |
| 2. роман | b) Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” |
| 3. тууж | c) Л.Түдэв “Хорвоотой танилцсан түүх” |
| 4. яруу найраг | d) Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” |
| 5. өгүүллэг | e) Б.Ренчин “Шүхэрч Буниая” |

- | | | |
|-------------------|-------------------|-------------------|
| A. 1d,2b,3c,4a,5e | B. 1a,2d,3b,4c,5e | C. 1d,2b,3a,4c,5e |
| D. 1b,2d,3e,4a,5c | E. 1b,2c,3e,4a,5d | |

24. Дараах эшлэлүүдээс нар, сарны дүрслэл нь бусдаасаа ялгаатай хэсгийг олоорой.

- A. Дорнын цагаан саран шөнөжин дуулж хононо
Дотно янаг хүүтэйгээ насаараа цэнгэж суумаар
- B. Сартай толгодод ингэ гунганах нь сайхан
Шанзны үзүүрт Ай-Нанаа суух сайхан
- C. Нар бүлэгнэн мандахаас өмнө
Сар дүлэгнэн жаргахаас урьд
- D. Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт
Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
- E. Сар өдрүүд шувууд шиг нисэн одлоо
Салхин зүгээс агь үнэртэн навчис хийслээ

25. “Авах гээхийн дөрвөн мөрт” шүлэгт дарааллаар тохирох хэсгийг олоорой.

Дөрвөн мөнх аль буй хэмээвээс

Бодь хутаг хүртэл үл сүйдэхийн тул зорьсон мөнх
Булаах хулгай дор үл автахын тул сонссон мөнх
Буруу мөртэй үл одохын тулд амирласан мөнх
Буцалтгүй магад амсахын тул үйлийн мөнх

- | | |
|------------------------------|------------------------------|
| A. нирваан, буян, үр, эрдэм, | B. нирваан, эрдэм, буян, үр |
| C. буян, эрдэм, нирваан, үр | D. буян, үр, эрдэм, нирваан, |
| E. буян, нирваан, эрдэм, үр | |

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

a. чөмөг хатаж, шөрмөс сунах	1. ямар нэг сайхан юмны хойноос хөөцөлдөмтгий
b. хаалгаар багтахaa болих	2. олон газраар явах; хол ойр явж туршлага суух
c. юм үзэж, нүд тайлах	3. туйлын ядарч зүдрэх
d. яргуй хөөсөн ямаа шиг	4. хуурч мэхлэх
e. цонхны цаанаас чихэр долоолгох	5. их зан гаргаж айлд орохоо болих

2.2. Уран зохиолын төрөл зүйлүүдийг зохиолын хэсэгтэй нь зөв харгалзуулаарай.

- | | | |
|------------------|----|---|
| a. Ерөөл | 1. | Ган зуднаас хамгаалдаг
Гайхам сайхан Алтай минь |
| b. Магтаал | 2. | Шар суран ногттой, өндөр хөх буур унасан залуу тариачин эр миний
цонхон доогуур өнгөрөв
Эрлийг сургаар олдог |
| c. Зүйр цэцэн үг | 3. | Эрдмийг хичээлээр сурдаг |
| d. Өгүүлэг | 4. | Эрт цагт хүмүүс гар хөл нь тахийж одох болсонд Бурхан багш Лусын
хааньд хүрч нутаг амьтнаа жаргалтай болгохыг эрж ирлээ гэжээ
Буянт их настандаа сайшаагдаж |
| e. Домог | 5. | Буйгаараа хамтаар жаргахын билгийг айлтгая |

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

	1	2	3	4	5
a. Балархай эгшиг гээгдэхгүй үг	нөхцөл+ийг	өнцөг+ийг	хамаг+ийн	ганга+аар	бэлдэц+ийн
b. Зөөлний тэмдэг үл солигдох үг	захь+аа	тохь+той	хумь+х	боль+лоо	хувь+тай
c. “-ё”-г шууд залгах үг	бороош	хүлээ	хороо	орооцолд	богтол
d. Эр үгэнд “-ыг” бичих үг	гавж	хайлаас	тоног	урхи	углааш
e. “-л” өмнөө эгшигтэй бичигдэх үг	ном	хавтас	хичээл	хайч	үзүүр

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

a. 	1. тал хээр
b. 	2. даалуу үүлүү
c. 	3. дэл сүүл
d. 	4. дал ная
e. 	5. дал мөр

Д/д	A хувилбар	D хувилбар	Оноо
1	B	D	2
2	A	E	2
3	E	D	2
4	D	C	2
5	E	C	2
6	C	D	2
7	B	E	2
8	C	A	2
9	B	D	2
10	A	B	2
11	E	C	2
12	D	D	2
13	B	E	2
14	C	A	2
15	A	C	2
16	E	A	2
17	D	A	2
18	E	D	2
19	C	B	2
20	B	B	2
21	C	D	2
22	B	B	2
23	D	A	2
24	E	E	2
25	A	C	2
26	D	C	2
27	E	D	2
28	E	E	2
29	A	A	2
30	D	B	2

31	C	D	2
32	A	E	2
33	A	A	2
34	D	D	2
35	D	C	2
36	A	B	2
37	E	A	2
38	B	A	2
39	D	E	2
40	E	D	2
2.1.	a-3	a-3	1
	b-5	b-5	1
	c-2	c-2	1
	d-1	d-1	1
	e-4	e-4	1
2.2.	a-4	a-5	1
	b-5	b-1	1
	c-1	c-3	1
	d-2	d-2	1
	e-3	e-4	1
2.3.	a-1	a-1	1
	b-5	b-5	1
	c-3	c-3	1
	d-4	d-2	1
	e-4	e-4	1
2.4.	a-3	a-3	1
	b-4	b-5	1
	c-1	c-4	1
	d-5	d-2	1
	e-2	e-1	1